



“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

**ДОТООД АУДИТ МОНИТОРИНГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ III-Р УЛИРЛЫН ТАЙЛАН**

2023 ОН

Ц.Мөнх-очир

Дотоод хяналт-шалгалтын зорилго, зарчим, хамрах хүрээ

Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмын хүрээнд зохион байгуулан ажиллана.

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, Зам тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, шийдвэр болон төвийн захирлын тушаал шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлт, төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүний бүртгэл тооцоо, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн дотоод журам, төвийн захирлын, Зам тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан “Ажил үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-ний биелэлт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай, газрын захирлын байгуулсан гэрээ зэрэгт байнгын хяналт тавих, төлбөр авах нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөвлөмж өгөх, хууль зөрчсөн ажилтанд хариуцлага тооцох, удирдлагыг мэдээллээр хангах, боломжит нөөц бололцоог илрүүлж, үр ашигтай замыг тодорхойлоход дотоодын хяналт, шалгалтын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Дотоодын хяналт шалгалтын зорилго нь тухайн байгууллагын үйл ажиллагаа нийтэд үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь Монгол улсын хууль, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ажлын хариуцлага алдсан ажилтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхэд чиглэн ажиллаж байна.

1. Газрын захирлын шуурхай хурлын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ хийх, удирдлагад танилцуулах

Зорилго: “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирлыг ажлын мэдээ болон бусад мэдээллээр хангах.

Энэхүү ажлын хүрээнд:

Эхний хагас жилд захирлын дотоод шуурхай хурал 17 удаа хуралдаж, 190 үүрэг даалгавар өгсөн байна. Хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг, захирлын туслах холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн боловсруулсан. Тухайн нэгтгэн боловсруулсан биелэлтийг хянан ажиллаж байна.

Үүнд:

- 100% биелсэн үүрэг даалгавар – 76
- 60-90% биелсэн үүрэг даалгавар – 54
- 50%-аас доош биелсэн үүрэг даалгавар – 46

Удаашралтай үүрэг даалгаврын биелэлтэд 50 хувиас доогуур үнэлгээ авсан 15 ажлыг эрчимжүүлэх, зорилтот түвшинг хангуулахаар үүрэг, чиглэл өгч ажиллаж байна.

2. Байгууллагын санхүүгийн чиглэлээр

Зорилго: Байгууллагын санхүү, эдийн засаг, үр ашгийн тооцоололд хяналт тавин үргүй зардал гаргахгүй байх.

Энэхүү ажлын хүрээнд:

Зам, тээврийн хөгжлийн төв болон авто замын шилэн дансны мэдээллийг байгууллагын дотоод аудитын мэргэжилтэн shilendans.gov.mn сайтад нэвтрэн оруулж санхүүгийн орлого болон зардлыг тогтмол хянан ажиллаж байна. Мөн улирал тутамд 20 АЗЗА байгууллагуудыг мэдээллийг хянаж “Зам, тээврийн яам”-ны, хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

3. Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах

Зорилго: Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах. Мөн ажлын байранд заасан чиг үүргийн хүрээнд ажлыг бүтээмжийг дээшлүүлэх.

Энэхүү ажлын хүрээнд:

- Захиргаа Санхүүгийн хэлтэс – 33 албан хаагч
- Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтэст- 11 албан хаагч
- Эрдэм шинжилгээ судалгаа инновацын хэлтэст – 7 албан хаагч
- Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторт – 15 албан хаагч
- Авто зам ашиглалтын хэлтэст – 14 албан хаагч
- Барилга угсралтын хяналтын хэлтэс – 5 албан хаагч
- Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс – 9 албан хаагч
- Гэрээт албан хаагчид – 298 ажлын байрны тодорхойлолтыг тус тус боловсруулсан.

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/09 тоот тушаалаар батлагдсан байгууллагын үндсэн 94, гэрээт 298 ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж холбогдох хэлстийн дарга нар болон нийт албан хаагчдаас саналыг авч боловсруулан ажлын хэсгийг ахлан ажилласан.

4. Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн орон нутгийн төлбөр авах цэгүүдэд хяналтаар ажиллах

Зорилго: Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн төлбөр авах цэгүүдэд хяналт-шалгалтыг хийж ажлын бүтээмжийг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх


Энэхүү ажлын хүрээнд:

Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн Эрдэнэсант, Ховд-Мянгад авто пүүг ашиглалтад оруулах Баян-Өлгий Сагсай, Увс Хандгайт, Завхан Сонгино, Их уул, Архангай Тариат, Ганц мод, Өвөрхангай Хархорин төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг хянан шалгах, Цахимжуулах ажлын хүрээнд нийт ажилчдад нэгдсэн ойлголт өгөх, сургалт орох, судалгаа хийх ажлаар томилогдон ажилласан. Мөн Баян-Өлгий, Увс хандгайт, Завхан Сонгино, Их уул, Архангай Тариат, Ганц мод, Хархорин төлбөр авах цэгүүдэд цахимжуулах ажлын хүрээнд нийт ажилчдад нэгдсэн ойлголтын талаар сургалт орох, судалгаа хийх, өмч хөрөнгийн хэрэглээ, ашиглалт, хамгаалалт, зааварчилгаа, бичиг баримтын эмх цэгц, ээлж хүлээлцсэн рапорт, ажлын цагийн бүртгэл цаг ашиглалт, ажлын байрны бэлэн байдал ХАБЭА-н шалгалт хийж ажилласан. Мөн “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020 стандартаар нэг тэнхлэг дээрх жин 11тонн, нийт жин 44 тонн байх стандартын шаардлагыг хангаж байгаа эсхийг хянаж, шалган ажилласан.

Мөн Улаанбаатар хотыг тойрсон цахимжсан төлбөр авах цэгүүдээр дотоод үйл ажиллагаанд хяналт-шалгалт шинжилгээ, үнэлгээ хийх журмын 4.1.1-д заасны дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гарсан зөрчлийг газрын захиралд танилцуулсан. Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэст 2 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Зөрчил

- ✓ Баян-Өлгий сагсай авто пүү дээр MNS 4598:2020 стандартыг зөрчин 62 тонн, 68 тонн ачсан хүнд даацын тээврийн хэрэгслийг түр саатуулан АТҮТ-ын байцаагчид хүлээлгэн өгч арга хэмжээг авхуулсан.
- ✓ Ховд-Мянгад авто пүү дээр MNS 4598:2020 стандартыг зөрчин 1573 ХОЕ улсын дугаартай нүүрс тээвэрлэж явсан хүнд даацын машин жин тонн хэтрүүлснийг орон нутгийн тээврийн цагдаагийн албанд хүлээлгэн өгсөн.



➤ **Нийт ажилтан, албан хаагчдад харилцааны өндөр соёлтой түргэн шуурхай ажиллах зөвлөмжийг хүргүүлэх чиглэлээр**

Энэхүү ажлын хүрээнд:

Дотоод үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу байгууллагын нийт ажилтан, албан хаагчид, инженер техникийн ажилтан , бүсийн инженерүүд, төлбөр авах цэгт ажилладаг төлбөр хураагч нарт олон нийтэд ил тод, нээлттэй, түргэн шуурхай, харьцааны өндөр соёлтой ажиллах заавар, зөвлөгөөг хүргүүлэн ажилласан.



Үр дүн: Монгол Улсын Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын удирдлагууд нийт ажилтан, албан хаагчидаа авилга, ашиг сонирхлын гэмт хэргээс ангид байхад чиглэсэн ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна.

5. Засгийн газраас хэрэгжүүлж буй шүүр ажиллагааны хүрээнд

Зорилго: Засгийн газраас 2023 оныг авилгатай жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлж буй шүүр ажиллагаа нь нийтийн албанд хүнд суртал авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн.

Энэхүү ажлын хүрээнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Зам тээврийн хөгжлийн яамнаас шүүр ажиллагааны хүрээнд гаргасан удирдамжийн дагуу шалгалтын баг манай байгууллагад ажилласан. Тус ажлын хүрээнд манай газар дотоод аудитаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан хүний нөөцийн бодлогын бичиг баримтын бүрдүүлэлт ханган дутуу бичиг баримтуудыг бүрдүүлж шүүр ажиллагааны хүрээнд шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлсэн.

6. Авто зам ашиглалтын хэлтсийн хариуцдаг олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлыг хангуулах чиглэлээр

Зорилго: Олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтыг сайжруулах, иргэдийн эрүүл, аюулгүй зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах

Энэхүү ажлын хүрээнд:

Хөвчийн зам ХХК, Архангай АЗЗА ТӨХК, Хархорин АЗЗА ТӨХК-ийн хариуцдаг олон улс, улсын чанартай авто замуудын их засвар болон ээлжит засварын ажлуудыг АЗАХ-ийн дарга, бүсийн инженерийн хамт ажлын тоо, үер, усны үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг шалган ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:

 Ц.МӨНХ-ОЧИР